

САНХҮҮГИЙН ГҮЙЦЭТГЭЛ 2023 ОНЫ 4 ДҮГЭЭР УЛИРАЛ

/Аудитлагдаагүй, Монголбанк суурьтай/

2024 оны 1 сарын 15

САНХҮҮГИЙН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ /2023 он/


2023 оны хувьд уул уурхайн салбарын сэргэлтийн нөлөөгөөр эдийн засгийн өсөлттэй жил байлаа. Гуравдугаар улирлын байдлаар эдийн засгийн өсөлт 6.9 хувьтай гарав. 2023 онд чулуун нүүрсний экспорт 66.7 сая тоннд хүрснээр 2022 онд алдагдалтай байсан төлбөрийн тэнцэл 11-р сарын байдлаар 964 сая ам.долларын ашигтай гарав. Үүний улмаас 2023 оны эцэст гадаад валютын албан нөөц 4.9 тэрбум ам.долларт хүрч төгрөгийн ханш 2023 оны 3-р сараас эхлэн ам.долларын эсрэг бага зэрэг чангарч байна. 2023 онд инфляцын эрсдэлээс хамгаалан бодлогын хүү 13.0 хувь буюу өндөр хэвээр хадгалагдсан жил байлаа. Улмаар 21 сарын турш 2 оронтой байсан инфляц 1 оронтой тоонд орж 12-р сарын байдлаар 7.9 хувьд хүрч буурав.

2023 онд банкны харилцагчийн эх үүсвэр 37.5%, цэвэр зээл 26.8%-р тус тус өсөв. 11-р сарын эцсийн байдлаар банкны салбарын зах зээлд эзлэх хувь харилцагчийн эх үүсвэрийн хэмжээгээр 20.3%, зээлийн хэмжээгээр 16.8%-д тус тус хүрэв.

Зах зээл дээр хүүгийн түвшин өндөр байсантай холбоотой 2023 оны эцсийн байдлаар хүүгийн орлого өмнөх оноос 43.7%-р, цэвэр хүүгийн орлого 25.7%-р өсөж 454.7 тэрбум төгрөгт хүрлээ. Хүүгийн бус орлогын хувьд шимтгэл хураамжийн орлого өмнөх оноос 21.4%-р өссөн байна. Өнгөрсөн онтой харьцуулахад валютын ханш илүү тогтвортой байсантай холбоотой арилжааны ашиг 44.4%-р буурч 59.0 тэрбум төгрөгт хүрэв. Зардлын хяналтыг хэрэгжүүлснээр зардал орлогын харьцааг 35.0%-д хадгалж чадлаа. Сан үнэлгээний зардлын өмнөх, свопын нөлөөгүй үйл ажиллагааны цэвэр ашиг 4.7%-р өсөж 368.8 тэрбум төгрөгт хүрэв.

Активын чанарын удирдлагыг амжилттай хэрэгжүүлснээр чанаргүй зээлийн харьцаа (NPL) 6.9%-аас 5.0% хүрч буурсан бол сан үнэлгээний зардал 88.4%-р буурч 22.4 тэрбум төгрөгт хүрэв. 2023 оны татварын дараах цэвэр ашиг өмнөх оноос 80.0%-р өсөж 180.8 тэрбум төгрөгт хүрээд байна. Мөн цэвэр хүүгийн ахиуц харьцаа (NIM) 2022 оны эцэст 5.7%-с 6.3%-д хүрч, Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE) 14.4%-с 20.5%-д хүрч сайжрав. Нэгж хувьцаанд ногдох ашиг (EPS) 223.6 төгрөгт хүрч өслөө.

ЗАХ ЗЭЭЛД ЭЗЛЭХ ХУВЬ /2023 оны 11-р сар/



Арилжааны хэмжээ
28%



Онлайн худалдааны
гүйлгээний тоо, дүн
69%, 45%

Q3'2023 байдлаар



Кастодиан банкны
харилцагчийн тоо
44%



Орон сууцны зээл
24%



Кредит карт
46%



Аккредитивын хэмжээ
66%

Эх сурвалж: Монголбанкны статистик ашиглав


БАЛАНСЫН ГҮЙЦЭТГЭЛ Q4'2023

| Балансын үзүүлэлт (тэрбум ₮) | 2022Q4 | 2023Q4 | YoY | % |
|---|--------------|---------------|----------------|--------------|
| Мөнгө ба түүнтэй адилгах хөрөнгө | 2,238 | 3,614 | 1,375.1 | 61.4% |
| Банк санхүүгын байгууллагад байршуулсан хөрөнгө | 1,439 | 1,203 | (236.1) | -16.4% |
| Хөрөнгө оруулалт | 699 | 1,175 | 475.7 | 68.0% |
| Цэвэр зээл | 3,608 | 4,576 | 968.3 | 26.8% |
| Үндсэн хөрөнгө | 385 | 559 | 173.8 | 45.1% |
| Бусад актив | 556 | 343 | (213.3) | -38.4% |
| Нийт хөрөнгө | 8,925 | 11,469 | 2,543.4 | 28.5% |
| Харилцагчдын эх үүсвэр | 5,620 | 7,725 | 2,105.0 | 37.5% |
| Харилцах | 2,703 | 3,979 | 1,276.6 | 47.2% |
| Хадгаламж | 2,917 | 3,745 | 828.4 | 28.4% |
| Банк санхүүгын байгууллагаас татсан эх үүсвэр | 1,999 | 2,193 | 193.3 | 9.7% |
| Бусад эх үүсвэр | 306 | 380 | 73.4 | 24.0% |
| Бусад өр төлбөр | 156 | 225 | 68.4 | 43.8% |
| Нийт өр төлбөр | 8,082 | 10,522 | 2,440.2 | 30.2% |
| Нийт өөрийн хөрөнгө | 844 | 947 | 103.2 | 12.2% |
| Чанаргүй зээлийн харьцаа | 6.9% | 5.0% | | |
| Эрсдэлийн хүрэлцээний харьцаа | 96.4% | 106.2% | | |
| Өөрийн хөрөнгийн хүрэлцээ (CAR, Tier 1) | 17.7% | 15.9% | | |
| ТПГЧ-ын харьцаа | 36.3% | 38.3% | | |

Балансын гүйцэтгэл:

- Харилцагчдын эх үүсвэр өнгөрсөн оноос 2.1 их наяд төгрөгөөр /37.5%/ өсөж 7.7 их наяд төгрөгт хүрэв. Нийт өсөлтийн 66%-г Корпорэйт сегмент, 21%-г Ритэйл сегмент, үлдсэн 13%-г ЖДБ сегмент бүрдүүлж байна.
- Цэвэр зээл 968.3 тэрбум төгрөгөөр /26.8%/ өсөж 4.6 их наяд төгрөгт хүрэв. Нийт өсөлтийн 55%-г Ритэйл зээлийн өсөлт бүрдүүлж байна.
- Банк 4-р сард нэгж хувьцаанд 50 төгрөг буюу нийт 40.4 тэрбум төгрөгийн ногдол ашиг тараав /DPR=40%/. Өөрийн хөрөнгийн хүрэлцээ (CAR) болон 1-р зэргийн өөрийн хөрөнгийн (Tier1) хүрэлцээний харьцаа 15.9%-д хүрэв.

Сегментийн бүтэц (%)*



* Дотоод сегментийн бодлогын дагуу



ОРЛОГЫН ТАЙЛАНГИЙН ГҮЙЦЭТГЭЛ Q4'2023

| Орлогын тайлан (тэрбум ₮) | 2022Q4 | 2023Q4 | ҮоҮ | % |
|--|--------------|--------------|----------------|----------------|
| Хүүгийн орлого | 669.5 | 962.0 | 292.6 | 43.7% |
| Хүүгийн зардал | 307.9 | 507.3 | 199.5 | 64.8% |
| Цэвэр хүүгийн орлого | 361.6 | 454.7 | 93.1 | 25.7% |
| Цэвэр хүүгийн бус орлого | 150.9 | (3.1) | (153.9) | -102.0% |
| Шимтгэл хураамжийн орлого | 85.1 | 103.3 | 18.2 | 21.4% |
| Цэвэр арилжааны ашиг | 100.4 | (56.4) | (156.8) | -156.1% |
| Арилжааны ашиг | 106.0 | 59.0 | (47.0) | -44.4% |
| СВОП-ын нөлөө | (5.6) | (115.4) | (109.7) | 1949.0% |
| Бусад хүүгийн бус орлого | 20.5 | 13.0 | (7.4) | -36.3% |
| Хүүгийн бус зардал | 55.1 | 63.0 | 7.9 | 14.3% |
| Үйл ажиллагааны орлого | 512.5 | 451.6 | (60.8) | -11.9% |
| Үйл ажиллагааны орлого /СВОП-гүй/ | 518.1 | 567.0 | 48.9 | 9.4% |
| Үйл ажиллагааны зардал | 165.9 | 198.3 | 32.3 | 19.5% |
| Үйл ажиллагааны ашиг | 346.6 | 253.4 | (93.2) | -26.9% |
| Үйл ажиллагааны ашиг /СВОП-гүй/ | 352.2 | 368.8 | 16.6 | 4.7% |
| Эрсдэлийн сангийн зардал | 192.6 | 22.4 | (170.2) | -88.4% |
| Татварын өмнөх ашиг | 154.0 | 231.0 | 77.0 | 50.0% |
| Татварын зардал | 53.5 | 50.2 | (3.3) | -6.2% |
| Цэвэр ашиг | 100.5 | 180.8 | 80.3 | 80.0% |
| Цэвэр хүүгийн ахиуц* | 5.7% | 6.3% | | |
| Зардал орлогын харьцаа /СВОП-гүй/ | 32.0% | 35.0% | | |
| Өөрийн хөрөнгийн өгөөж | 14.4% | 20.5% | | |
| Нийт хөрөнгийн өгөөж | 1.2% | 1.9% | | |


* Дотоод аргачлал

Ашигт ажиллагааны гүйцэтгэл:

- Цэвэр хүүгийн орлого өнгөрсөн оноос 25.7% өсөж 454.7 тэрбум төгрөгт хүрэв.
- Цэвэр хүүгийн бус орлогын хувьд сөрөг -3.1 тэрбум төгрөг гарсан бөгөөд хэрэв СВОП-ын нөлөөн хасаж тооцвол 112.3 тэрбум төгрөгийн цэвэр орлоготой ажиллав.
 - Шимтгэл хураамжийн орлого 21.4%-р өсөж 103.3 тэрбум төгрөгт хүрсэн байна.
 - Зах зээлийн нөхцөл байдлын нөлөөгөөр арилжааны ашиг өнгөрсөн оноос 44.4%-р буурч 59.0 тэрбум төгрөгт хүрэв.
 - Мөн зах зээлийн нөхцөл өмнөх жилээс өөрчлөлттэй байсантай холбоотой СВОП-ын сөрөг нөлөөтэй байв.
- Сангийн зардлын өмнөх цэвэр үйл ажиллагааны ашиг 4.7%-р өсөж 368.8 тэрбум төгрөгт хүрсэн үр дүнтэй байна.
- Татварын дараах цэвэр ашиг өнгөрсөн оноос 80.0%-р өсөж 180.8 төгрөгт хүрэв.
- Ашигт ажиллагааны харьцаа үзүүлэлтүүдээр өнгөрсөн оноос сайжирсан үр дүнтэй байна. Нэгж хувьцаанд ногдох ашиг (EPS) 223.6 төгрөгт хүрэв.

Г САНХҮҮГИЙН ГҮЙЦЭТГЭЛ 2023

Улирлын цэвэр ашиг /тэрбум ₮/ -Монголбанкны аргачлалаар



Улирлын цэвэр ашгийн өсөлт(QOQ):

Q1'2023/Q1'2022 +47.6%


Q2'2023/Q2'2022 +29.2%

Q3'2023/Q3'2022 +146.7%


Q4'2023/Q4'2022 +128.8%

Санхүүгийн гүйцэтгэл 2023, IPO зорилт /тэрбум ₮/ -СТОУС-ын дагуу


Нийт зээл: 12%-р давж биелүүлэв



Эх үүсвэр: 14%-р давж биелүүлэв



Цэвэр ашиг: 44%-р давж биелүүлэв



* Аудитлагдаагүй

АНХААРУУЛГА

Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасны дагуу аж ахуйн нэгж, байгууллагууд нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ыг мөрддөг бол Арилжааны банк нь Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн багц материал”-ыг дагаж мөрддөг. Энэхүү журамд 2017 оноос хойш шинэчлэгдсэн зарим стандарт (СТОУС-9, СТОУС-15, СТОУС-16 гэх мэт)-ын өөрчлөлтийг тусгаагүй байдаг. Иймд дээрх журмын дагуу бэлтгэн улирал бүр олон нийтэд мэдээлж буй тайлан нь Банкны СТОУС-т нийцсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй байж болох ба зээл, эх үүсвэрийн сегментийн бүтцийг банкны дотоод аргачлалд тулгуурласан болно.

Анхаарал тавьсанд баярлалаа